# ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 01 өдөр Дугаар Б/41 Улаанбаатар хот

Д.Хунцэцэгийг Шинэ бүтээлийн шинжээчийн албан тушаалд томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, мөн зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаал зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам батлах тухай” 382 дугаар тогтоол, 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны Оюуны өмчийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хөтөлбөр, бүтцийг батлах тухай” А/123 дугаар тушаал, Авлигатай тэмцэх газрын 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 05/70540 тоот албан бичийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дарьбазар овогтой Хунцэцэгийг 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Аж үйлдвэрийн өмчийн хэлтсийн Шинэ бүтээлийн шинжээчээр томилсугай.

2. Д.Хунцэцэгт ажлыг хүлээлгэн өгч, ажил хүлээлцсэн тухай тэмдэглэлийг 2020 оны 07 дугаар сарын 1-ний өдрийн дотор Захиргаа удирдлагын хэлтэст ирүүлэхийг Аж үйлдвэрийн өмчийн хэлтсийн дарга / С.Урангэрэл/-д үүрэг болгосугай.

3. Д.Хунцэцэгийн ажлыг зохих журмын дагуу тэмдэглэл үйлдэн 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор авахыг Зохиогчийн эрхийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бат-Эрдэнэ, мэргэжилтэн Б.Хэрлэнчимэг, Г.Ууганцэцэг нарт үүрэг болгосугай.

4. Д.Хунцэцэгт албан тушаалын цалинг төрийн захиргааны албан хаагч дэс түшмэл ангилал, ТЗ-7-3 зэрэглэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 15 хувь, төрийн захиргааны албан тушаалын дэс дүшмэлийн дэд зэргийн нэмэгдэл 22 хувь болон хоол унааны нөхөн төлбөрийг холбогдох журмын дагуу тус тус тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Оюунцэцэг/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА Ц.АЗБАЯР

0008